

СОНГУУЛИЙН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо /цаашид “Хороо” гэх/-ны хуралдааны зохион байгуулалтын үйл ажиллагаанд энэхүү дэгийг баримтална.

1.2. Хуралдаан нь хууль дээдлэх, дэгийг чанд сахих, асуудлыг чөлөөтэй хэлэлцэх, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэх, олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэн явагдана.

1.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу хуралдаанд сонгуулийн хорооны нийт бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

1.4. Сонгуулийн хороо Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу хуульд заасан бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон бүрэлдэхүүний олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана.

1.5. Сонгуулийн хорооны хуралдаан нь нээлттэй ил тод байх бөгөөд хуралдааны ажиллагаа, шийдвэрийн талаар нийтэд ил тод мэдээлнэ.

Хоёр. Хуралдааны бэлтгэл хангах

2.1. Хорооны нарийн бичгийн дарга хуралдааны бэлтгэлийг хангах бөгөөд хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, хорооны даргад танилцуулна.

2.2. Хорооны нарийн бичгийн дарга хуралдаан эхлэхээс өмнө хэлэлцэх асуудалтай холбогдох баримт бичгийг Хорооны даргад танилцуулж, гишүүдэд тараасан байна.

2.3. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан мэргэжлийн байгууллага, бусад этгээдийн саналыг урьдчилан авч болно.

Гурав. Хуралдаан хийх

3.1. Хуралдааныг хорооны дарга удирдан явуулах бөгөөд хорооны даргын түр эзгүйд түүний даалгаснаар хорооны аль нэг гишүүн хуралдааныг даргална.

3.2. Хорооны гишүүн хуралдаанд оролцох боломжгүй бол шалтгаанаа Хорооны даргад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

3.3. Хуралдааны явцад дараах дэгийг баримтална:

3.3.1. хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн асуудлын дарааллыг хуралдаан даргалагч танилцуулах ба хэлэлцэх асуудлыг батлуулах;

3.3.2.хуралдааны төлөвлөгөөнд ороогүй боловч хэлэлцэх шаардлагатай асуудал гарвал аль нэг гишүүний санал оруулсанаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулах бөгөөд уг асуудлыг санаачилсан гишүүн нь байхад хэлэлцэх;

3.3.3.Нарийн бичгийн дарга эсхүл асуудлыг хэлэлцүүлэхээр санал оруулсан гишүүн хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу хуралдаанд танилцуулах;

3.3.4.хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт асууж тодруулга хийх;

3.3.5.асуулт, хариулт, тодруулга дууссаны дараа гишүүд санал гаргах;

3.3.6.хуралдаан даргалагч хэлэлцэж буй асуудлын талаар гарсан саналыг нэгтгэж, асуудал тус бүрээр санал хураах.

3.4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т заасны дагуу сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр орхисон тохиолдолд түүнийг хуралдаанд оролцож тухайн асуудлаар татгалзсан санал гаргасанд тооцно.

3.5.Шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудлын онцлогийг харгалзан хуралдаанд холбогдох этгээдийг оролцуулж болно.

3.6.Хуралдаан даргалагч дараах эрхтэй:

3.6.1.хуралдааны дэгийг сахиулах, биелэлтэд хяналт тавих;

3.6.2.хорооны гишүүд асуулт асуух, үг хэлэх, санал шүүмжлэл гаргахад зөвшөөрөл олгох;

3.6.3.хэлэлцсэн асуудлаар санал хураалгаж, дүнг мэдээлж, шийдвэрийг сонсгон батлуулах.

3.7.Хуралдааныг завсарлагатай хийж болох бөгөөд завсарлах хугацаа нэг цагаас илүүгүй байна.

3.8.Хуралдаан дууссаны дараа гишүүд санал дүгнэлт хийсэн баримт бичгийн төслийг холбогдох баримт бичгийн хамт нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

3.9.Хуралдааны танхимын багтаамжийг харгалзан сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, ажиглагч, төрийн бус байгууллагын ажилтныг байлцуулж болно. Хуралдаанд оролцогчид хуралдааны дэгийг чанд сахих үүрэгтэй.

Дөрөв. Хуралдааныг баримтжуулах, шийдвэрийг албажуулах

4.1.Хуралдааныг баримтжуулах ажлыг Хорооны нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулна.

4.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-д заасны дагуу сонгуулийн хорооны тогтоолд хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна.

4.3.Сонгуулийн хороо хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, гарын үсэг зурсан шийдвэрийн эх хувийг зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

4.4.Хуралдаанаар шийдвэрлэсэн асуудалд зарчмын шинжтэй өөрчлөлт оруулах тохиолдолд хуралдаанаар дахин хэлэлцүүлж, энэ журамд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Тав. Хориглох зүйл

5.1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т зааснаас гадна аливаа этгээд дараах үйлдэл хийхийг хориглоно:

5.1.1.хуралдаанаас гарсан шийдвэрт агуулгын өөрчлөлт хийх;

5.1.2.хуралдаан даргалагчийн зөвшөөрөлгүйгээр хуралдааны танхимд орж гарах, үг хэлэх;

5.1.3.хуралдаан даргалагчийн зөвшөөрөлгүйгээр гар утсаар ярих, дуут болон дүрс бичлэг хийх;

5.1.4.тухайн сонгуулийн хорооны бүрэн эрхийн асуудалд хөндлөнгөөс оролцох, хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулах.

Зургаа. Хариуцлага

6.1.Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ дэгд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---